



ХУДАЛДАА
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИХ СУРГУУЛЬ

2019-2025

СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

• Бүрэн эрдэм • Бүтээлч чанар •



**ХУДАЛДАА
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИХ СУРГУУЛЬ**



**Улаанбаатар хот
2019 он**

АГУУЛГА

ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛС	2
Эрхэм зорилго	2
Алсын хараа	2
Үнэт зүйлс	2
Уриа	2
СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	3
1. Сургалтын шинэчлэлийн стратеги	3
2. Эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлэх стратеги	9
3. Нийгэмд нөлөө бүхий жишиг байгууллага болох стратеги	10
4. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	13
5. Стратегийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ	14
6. ХҮИС-ийн сургалтын боломжит хөтөлбөрүүд	15
СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦААНД ТУСГАЙЛАН БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД	23
САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
ХАВСРАЛТ	25

ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИХ СУРГУУЛИЙН СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2019-2025

ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛС

ЭРХЭМ ЗОРИЛГО

Мэдлэг, ур чадвараа нийгмийн баялгийг бүтээхэд зориулах худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнесийн салбарын шинийг санаачлагч, хөрвөх чадвартай манлайлагчдыг бэлтгэх, нийгэм, эдийн засгийн салбарт судалгаа, шинжилгээний чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оршино.

АЛСЫН ХАРАА

2025 он гэхэд худалдаа, үйлчилгээний технологи, бизнесийн сургалт, судалгааны түшиц Монгол улсдаа тэргүүлэх их сургууль болоход оршино.

ҮНЭТ ЗҮЙЛС

- **Академик эрх чөлөө**

Бид академик эрх чөлөөг дээдлэн, хэвшил болсон сэтгэлгээний оронд шинийг эрэлхийлэгч байж, суралцагчдаа оюунлаг энтерпренер болгон төлөвшүүлэхийг эрхэмлэнэ.

- **Ёс зүй**

Бид оюутнаа ёс зүйтэй судлаач, нийгэмд хариуцлагатай мэргэжилтэн болгон төлөвшүүлэхийг эрхэмлэнэ.

- **Ил тод, нээлттэй байдал**

Бид ил тод, нээлттэй, шударга, үл алагчлах ёсыг эрхэмлэнэ.

- **Хамтын засаглал**

Бид олон талын оролцоог хангасан хамтын засаглалын зарчимд суурилсан, нэгдэн нягтарсан хамт олон болж, байгууллагынхаа урт хугацааны хөгжлийг тогтвортой хангахыг эрхэмлэнэ.

- **Хамтын ажиллагаа, түншлэл**

Бид ажил олгогчид, худалдаа, бизнесийн байгууллагуудтай нягт хамтын ажиллагааг хөгжүүлж, сургалт, үйлдвэрлэлийн үр ашигтай түншлэлийг бий болгон, нийгмийн хариуцлагатай бизнесийг дэмжин ажиллана.

- **Мэдлэг бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх**

Бид мэргэжлийн мэдлэг бүтээгч, түүнийгээ хэрэглээнд нэвтрүүлэгч байж худалдаа, бизнесийг олон улсын жишиг, орчин үеийн арга технологийн дагуу шударга, харилцан ашигтай байдлаар эрхлэхийг бүхий л талаар хөхүүлэн дэмжиж, нийгмийн баялаг бүтээгч үүргийг дээшлүүлэхийг эрхэмлэнэ.

- **Ногоон, эко орчин**

Бид сургуульдаа эко орчныг бүрдүүлэн, нийгмийн тогтвортой хөгжилд чиглэсэн сургалт, судалгаа, үйлчилгээг тууштай хэрэгжүүлэхийг эрхэмлэнэ.

УРИА

БҮРЭН ЭРДЭМ – БҮТЭЭЛЧ ЧАДВАР

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

1. Оюутнууддаа үйлдвэрлэл, үйлчилгээний олон талт түншлэлд тулгуурласан, бодит нөхцөлд дадлагажих боломж бүрдүүлэх замаар тэдний олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн суралцахуйн инновацлаг арга барил бүхий сургалтын олон төрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2. Улс орны худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнесийн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлнэ.
3. Нээлттэй, ухаалаг, ногоон эко орчныг бүрдүүлсэн, нийгэмд эерэг нөлөө бүхий жишиг байгууллага болон хөгжинө.

1. СУРГАЛТЫН ШИНЭЧЛЭЛИЙН СТРАТЕГИ

Зорилт 1.1 Орчин үеийн худалдаа, үйлчилгээ, бизнесийн өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэхийн тулд олон улсын болон үндэсний хэмжээнд тавигдаж буй шаардлагыг хангасан, бодит туршлагаар дадлагажиж суралцах нөхцөлийг бүрдүүлсэн олон төрлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

Хэрэгжүүлэх стратеги	Шалгуур үзүүлэлт
1.1.1 Бакалаврын болон магистрын хөтөлбөрүүдийг олон улсын болон үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэх	- Олон улсын ACBSP байгууллагаар магадлан итгэмжлүүлэх бизнесийн удирдлагын хөтөлбөрийн тоо – 9 - Үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэх хөтөлбөрийн тоо – 5
1.1.2 Сургалтын хөтөлбөрт олон улсын сайн туршлага, үндэсний мэргэжлийн стандарт, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн, онол практикийг зохистой хосолсон, бодит ажлын туршлагаар дадлагажиж, хөрвөх чадвар, хандлага төлөвшилт бүхий цогц чадамж эзэмшүүлэх, технологийн дэвшлийг шингээн ХҮИС-ийн ялгарах онцлогийг сургалтын хөтөлбөрт тусгаж шинэчлэн боловсруулах	- Сургалтын хөтөлбөр боловсруулах стандарт (удирдамж) батлах – 1 багц бичиг баримт - Шинэчлэн боловсруулсан хөтөлбөрийн тоо – 12
1.1.3 Гадаадын их сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийг 2+2, 3+1 зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх	- Хамтарсан хөтөлбөрийн тоо – 3
1.1.4 Худалдаа, маркетинг, менежментийн болон үйлдвэрлэлийн тодорхой чиглэлээр тусгайлан мэргэшүүлэх шинэлэг дэд хөтөлбөр боловсруулж, эдгээр мэргэжлээр анхдагч, тэргүүлэгчийн байр сууринд хүрэх	- Тусгайлан мэргэшүүлэх чигтэй шинээр боловсруулах дэд хөтөлбөрийн тоо – 2

<p>1.1.5 Нийгмийн хөгжил, зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ахисан түвшний салбар дундын (олон улсын худалдаа, эрх зүй гэх мэт) хөтөлбөрүүдийг боловсруулж, зорилтот бүлэгт санал болгох</p>	<ul style="list-style-type: none"> - Магистрын хөтөлбөрийн тоо – 3 - Докторын хөтөлбөрийн тоо – 1 - Ахисан түвшний оюутны нийт оюутанд эзлэх хувийн жин - 20 хувь
<p>1.1.6 Хөтөлбөрийн менежментийн циклд төгсөгч, ажил олгогч зэрэг практик мэдлэг, туршлага бүхий талуудын бодит оролцоог хангах</p>	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөр боловсруулах, батлах журамд заалт оруулах
<p>1.1.7 Төгсөгч бүр бизнес, худалдаа, эрх зүй зэрэг олон салбарыг хамран тодорхой асуудлаар судалгаа шинжилгээ хийх, бизнесийн төсөл, хөтөлбөр боловсруулах, бүтээгдэхүүний загвар/дизайн гаргах зэрэг бие даасан ажил гүйцэтгэн, хамгаалах</p>	<ul style="list-style-type: none"> - Журам (удирдамж) гаргах – 1 багц бичиг баримт - Сургалтын хөтөлбөрт тусгах
<p>1.1.8 Зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан удирдах түвшний болон мэргэшүүлэх богино хугацааны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Богино хугацааны сургалтын хөтөлбөрийн тоо – 10 Үүнд: удирдлагуудад зориулсан богино хугацааны сургалт, Засгийн газрын худалдан авалт, аудит, компанийн засаглал, цахим худалдаа, барааны гарал үүсэл, худалдаа ложистик, чөлөөт худалдааны хэлэлцээр, худалдааны эрх зүй, гэрээ хэлэлцээр, нягтлан бодох бүртгэл, санхүү болон гадаад хэлний зэрэг чиглэлээр - Сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо (стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаанд) - 1000
<p>1.1.9 Сургалтын чанарын дотоод баталгаажууллын тогтолцоог бүрдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Сургалтын чанарыг баталгаажуулах бодлогын бичиг баримтыг батлах – 1 багц бичиг баримт - Сургалтын чанарын баталгаажууллын чиг үүрэг бүхий бүтэц (эсвэл ажилтан)-тэй байх

<p>1.1.10 Сургуулийн хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд “хийнгээ суралцах”, арга зүйг тусгаж, практик дадал, ур чадвар эзэмшүүлдэг давуу тал бүхий зах зээлийн идэвхтэй тоглогч болох. Идэвхтэй сургалтын орчин үеийн технологи болох ‘тонгоруу’ сургалтын арга, кейсд суурилсан арга, асуудалд суурилсан арга, төсөлд суурилсан арга, симуляци гэх мэт аргыг хичээлд өргөн хэрэглэх</p>	<ul style="list-style-type: none"> - Идэвхтэй сургалтын аргыг бүх хичээлд нэвтрүүлэх - Хичээлийн цахим санг бүрдүүлэх – цахим хичээлийн тоо (хичээл бүрээр 5-аас доошгүй цахим лекц) - Хичээлд ашиглах кейс, симуляцийн сан бүрдүүлэх (мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл бүрээр 2-оос доошгүй) - Хичээлийн бие даалтын сан бүрдүүлэх (хичээл бүрээр 2-оос доошгүй) - Мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл бүрээр танхимын нийт цагийн 50 хувь нь онолын хэсэг, 50 хувь нь практик мэдлэг, чадвар олгох хэсэг байхаар хичээлийн хөтөлбөрт тусгах - болж байна.
<p>1.1.11 Мэргэжлийн зарим хичээлийг англи хэлээр заах</p>	<ul style="list-style-type: none"> - Англи хэлээр заадаг мэргэжлийн хичээлийн тоо – 3-аас доошгүй
<p>1.1.12 Ахисан түвшний суралцагчдыг дотоод болон гадаадын их сургуулиас хичээл сонгон судлах, Аж ахуйн нэгж, судалгааны байгууллагад дадлагажих боломжийг бүрдүүлсэн солилцоог дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Журам боловсруулах – 1 багц баримт бичиг - Солилцооны гэрээ байгуулсан гадаадын их сургууль – 2, дотоодын их сургууль – 3 - Аж ахуйн нэгж, судалгааны байгууллагад дадлагажих боломжийг бүрдүүлсэн гэрээний тоо – 10
<p>1.1.13 Технологийн ололт, дижитальчлалын орчинд худалдаа үйлчилгээнд дижитал борлуулалт, дижитал маркетинг, е-коммерс, хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг нэвтрүүлэх асуудлыг сургалтын хөтөлбөрт тусгах</p>	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах - Нэгж хичээлийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах
<p>1.1.14 Гадаадын тэргүүлэх их сургуулийн бизнесийн чиглэлийн бакалаврын хөтөлбөрийг өөрийн сургууль дээр “ижилсүүлэх хөтөлбөр”-ийн зарчмаар монгол хэл дээр хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - “Ижилсүүлэх хөтөлбөр”-ийн тоо – 1
<p>1.1.15 Оюутны солилцооны хөтөлбөрийн хүрээнд гадаадын их дээд сургуулийн оюутнуудад зориулсан олон улсын зуны сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн дагуу гэрээ байгуулсан гадаадын их сургуулийн тоо – 3 - Хөтөлбөрт хамрагдсан гадаад оюутны тоо (стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаанд) - 90

Зорилт 1.2 Шилдэг багшлах бүрэлдэхүүнийг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх стратеги	Шалгуур үзүүлэлт
1.2.1 Багшид сургалтын идэвхитэй арга технологи, судалгааны арга зүй эзэмших, гадаад хэлний мэдлэг чадвараа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх багшийн хөгжлийн цогц хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Багшийн хөгжлийн хөтөлбөрийг батлах – 1 багц баримт бичих - Багшийн хөгжилд зарцуулах жилийн төсөв - нийт сургалтын төлбөрийн 2 хувь
1.2.2 Ур чадвар, туршлагатай шилдэг бизнес эрхлэгч, ажил олгогч экспертүүдийг сургалтын үйл ажиллагаанд оролцуулан, хичээл заалгаж, дадлагын ажил удирдуулах	<ul style="list-style-type: none"> - Сургалтын нийт цагт эксперт багшаар заалгах цагийн хувийн жин – 10 хувиас доошгүй
1.2.3 Өндөр хөгжилтэй орны их сургуульд эрдмийн зэрэг хамгаалахыг дэмжих, зэрэгтэй багш нарыг татах, худалдаа, даатгал, гаалийн чиглэлийн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд сургуулийн оролцоог нэмэгдүүлэх замаар тэнхимүүдийн чадавхыг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> - Эрдмийн зэрэгтэй багшийн эзлэх хувийн жин – 40 хувь
1.2.4 Багш нарыг дотоод, гадаадын их сургууль, бизнесийн болон судалгааны байгууллагад ажиллахыг дэмжсэн судлаач багшийн академик солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Академик солилцооны гэрээтэй байгууллагын тоо – 20-иос доошгүй - Академик солилцоонд хамрагдсан багш – 5-аас доошгүй

Зорилт 1.3 Сургалтын орчин үеийн таатай орчныг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх стратеги	Шалгуур үзүүлэлт
1.3.1 Орчин үеийн тоноглол бүхий лаборатори, мэдээлэл, харилцааны технологид суурилан эрчимтэй сургалтын орчинг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Лабораторийн тоо – 2 - Хабын тоо – 3
1.3.2 Стратегийн түншлэлийн хүрээнд аж ахуйн нэгж, үйлдвэрлэл дээр оюутан дадлагажих бодит боломжийг олгосон дадлагын баазыг бүрдүүлж, тогтвортой, харилцан үр ашигтай болгох	<ul style="list-style-type: none"> - Аж ахуйн нэгж, байгууллага болон үйлдвэрлэлийн дадлагын баазын тоо – 60

1.3.3	Харэтайн амралт, “Сүхбаатар” хөлөг онгоц зэрэг сургуулийн үндсэн хөрөнгөнд түшиглэн дадлагын орчин үеийн бааз, олон улсын зуны сургалтын төвийг шинэчлэн байгуулах	- Сургуулийн орчин үеийн дадлагын бааз, зуны сургалтын төв – 2
1.3.4	Мэргэжлийн номын фонд, сургалт судалгааны цахим эх сурвалжийн санг баяжуулж, оюутны бие даан сурах хэрэгцээнд нийцсэн e-номын сан байгуулах	- Мэргэжлийн цахим номын тоо – 3000 - Багш оюутанд хүртээмжтэй цахим сангийн тоо (JSTOR гэх мэт) – 3-аас доошгүй - Цахим хичээлийн унших материалын тоо (хичээл бүрт) – 10-аас доошгүй
1.3.5	Ногоон, эрүүл, нээлттэй орчныг бүрдүүлэх	- Ногоон эко орчны 6 шалгуур үзүүлэлт

Зорилт 1.4 Элсэгчдийн бизнесийн сэтгэлгээг үнэлэх, оюутан өөрийгөө нээж, цаашдийн карьертаа нөлөө бүхий туршлага хуримтлуулж, сэтгэл ханамжтай суралцах боломжийг тэтгэсэн “ХҮИС-ийн онцлог” шинжийг агуулсан орчин нөхцөлийг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх стратеги		Шалгуур үзүүлэлт
1.4.1	Элсэгчдийн бизнесийн сэтгэлгээг үнэлэн, шилдэг оюутныг элсүүлэх, дэмжих тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх	- Тухайн жилд элсэгчдийн сургалтын төлбөрийн 3 хувиас доошгүй хэмжээгээр тэтгэлгийн санг бүрдүүлнэ - Сангийн хөрөнгийн жилийн өсөлт – 10 хувь - Тэтгэлэгт хамрагдсан оюутны нийт оюутанд эзлэх хувийн жин – 5 хувь
1.4.2	Оюутны мэргэжлийн клубуудыг дэмжих: бизнес инновацийн төв, бизнес инкубатор, старт-ап клубуудыг ажиллуулах	- Мэргэжлийн клубын тоо – 6 - Клубын үйл ажиллагаанд хамрагдсан оюутны тоо (жилд) – 300
1.4.3	ХҮИС-ийн шилдэг оюутанд зориулсан Аж ахуйн нэгж, байгууллагын нэрэмжит тэтгэлэг бий болгох	- Тэтгэлэг олгох гэрээ байгуулсан Аж ахуйн нэгж, байгууллагын тоо – 6 - Тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо – 15
1.4.4	Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулах	- Төвийн бодлогын бичиг баримт батлах (журам гэх мэт) – 1 багц бичиг баримт - Төв байгуулах – 1 төв
1.4.5	Төгсөгчийн ажил эрхлэлтийн түвшний судалгааг тогтмол хийх (2 жил тутам)	- Төгсөгчийн ажил эрхлэлтийн түвшин – 65 хувь
1.4.6	Оюутны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийх (жил тутам)	- Оюутны сэтгэл ханамжийн түвшин – 80 хувьд хүргэх

1.4.7 Оюутны сургууль дээрх ажил эрхлэлт болон Аж ахуйн нэгж, байгууллага дахь интерншипийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Интерншип хийж буй оюутны тоо (хувийн жин) –20 хувь - ХҮИС дээрх хагас цагийн оюутны ажлын байрны тоо – 3
1.4.8 Хичээлийн ба оюутны байранд оюутан бие даан болон багаар ажиллаж суралцах, эрүүл амьдрах таатай орчныг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Хичээлийн байран дахь оюутны чөлөөт орчин бүрдүүлэх – нийт талбайн 10 хувь - Оюутны байрны тохижилтод оюутны байрнаас олж буй орлого – 10 хувь
1.4.9 Оюутан хичээлээс гадуур бизнесийн болон энтерпренершипийн ур чадварт бодитоор суралцах хөтөлбөрийг багш нарын удирдлага дор хэрэгжүүлэх (жижиг худалдааны компани байгуулах, “Саятан” тоглоом, хувьцаа үнэт цаасны гүйлгээнд оролцох, бизнес төсөл бичих, шалгаруулах, нийгмийн энтерпренерийн хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр санхүүжилт босгох жижиг төслүүд санаачлан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх)	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрт хамрагдсан оюутны бакалаврын нийт оюутны тоонд эзлэх хувийн жин – 80 хувь - Хөтөлбөрийн жилийн санхүүжилт нь элсэлтийн хураамжийн орлого – 25 хувь
1.4.10 Оюутан “бие биедээ заангаа суралцах”-ыг дэмжих зорилгоор багш, оюутныг холбосон “гүүр” болон судалж буй хичээлийн хүрээнд давтлага өгөх, хэлэлцүүлэг удирдах зэрэг “сурах, суралцах” үйл ажиллагааг дэмжих	<ul style="list-style-type: none"> - Давтлага өгч буй оюутны тоо – 50
1.4.11 Оюутанд бизнес эрхлэгчидтэй харилцаа тогтоож, тэднээс өдөр тутам суралцах боломж бүрдүүлж “зөвлөгч”-тэй болгох “Менторшип” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрт хамрагдсан оюутны тоо – 72 - Бизнес менторын тоо – 12

2. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

Зорилт 2.1 Худалдаа, үйлдвэрлэл, бизнесийн чиглэлээр нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа хийх

Хэрэгжүүлэх стратеги	Шалгуур үзүүлэлт
2.1.1 ХҮИС-ийн давуу талд суурилсан судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох (тогтвортой үйлдвэрлэл, ногоон бизнес, ухаалаг хэрэглээ, худалдааны эрх зүй, хэлцэл г.м.)	- Тэргүүлэх чиглэлийн жагсаалт гарах – 1
2.1.2 Гадаад болон дотоодын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэдтэй хамтарсан судалгааг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх	- Дотоодын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо – 2 - Гадаадын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо – 1
2.1.3 Ахисан түвшний суралцагчдад зориулсан ассистантшипиийн хүрээнд “Судлаач оюутан” хөтөлбөр хэрэгжүүлэх	- “Судлаач оюутан” хөтөлбөрт хамрагдсан ахисан түвшний оюутан нь нийт оюутны 10 хувиас доошгүй - Ассистантшипт зарцуулах төсөв нь тухайн жилийн ахисан түвшний элсэгчдийн сургалтын төлбөрийн 10 хувиас доошгүй
2.1.4 Судалгааны үр дүнг үнэлэх үнэлгээний оновчтой тогтолцоо бүрдүүлэх замаар судалгаа болон шилдэг судлаачдыг дэмжих зохицуулалтыг оновчтой болгож, судлаач багшийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх	- Судлаач багшийг дэмжих хөтөлбөр – 1 бичиг баримт Багшийн ажил болон судалгааны үр дүнгийн үнэлгээний журам (танхимын болон судалгааны багц цагийн үнэлгээг тусгасан, ингэхдээ судалгааг чухалчилсан) – 1 багц бичиг баримт - Үндэсний болон олон улсын мэргэжлийн хөндлөнгийн хяналттай сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо (жилд) 7-оос доошгүй
2.1.5 Бизнесийн, төрийн ба төрийн бус байгууллагын захиалгат судалгаа, бодлогын судалгаа, төсөл хэрэгжүүлэх	- Захиалгат болон гэрээт ажил, судалгаа, төслийн тоо (жилд) – 3
2.1.6 “Салбар дундын судалгааны баг” бүрдүүлэн, нийгэм-эдийн засгийн хамтарсан судалгаа хийж, үр дүнг олон улсын бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлэх	- Олон улсын сэтгүүлийн бүртгэлийн санд орсон сэтгүүлд хэвлүүлэх өгүүллийн тоо (жилд) – 5

Зорилт 2.2 Худалдаа, ложистикийн судалгааны чиглэлээр үндэсний хэмжээний экспертиз хийх орчин нөхцлийг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх стратеги	Шалгуур үзүүлэлт
2.2.1 Барааны чанарын экспертизийн түшиц лаборатори байгуулах	- Лабораторийн тоо – 1
2.2.2 Гадаад болон дотоод худалдаа, бизнес, энтерпренершипийн (үнэ тариф, гаалийн бүрдүүлэлт, ложистик нийлүүлэлтийн сүлжээ, худалдааны олон талт зохицуулалт зэрэг) асуудлаар зөвлөх үйлчилгээний чадавхи бүрдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх,	- Тухайн салбарын багш нарын 10 доошгүй хувь нь эксперт болсон байх - Улсын хэмжээний бодлого тодорхойлох ажлын хэсэг, хэлэлцүүлэгт оролцсон багшийн тоо – 20-иос доошгүй
2.2.3 Бизнесийн зөвлөгөө өгөх салбар дундын сургалт судалгаа, туршилтын төв байгуулах	- Төвийн тоо – 1
2.2.4 Сургуулийн экспертизэд түшиглэсэн Гарааны компанийн үйл ажиллагааг эхлүүлэх	- Гарааны компанийн тоо – 3
2.2.5 “Тогтвортой үйлдвэрлэл, худалдааг дэмжих судалгааны төв” байгуулах	- Төвийн тоо – 1
2.2.6 “Корпорацийн инновацийн төв” байгуулах	- Төвийн тоо – 1
2.2.7 “Судалгааны сүлжээ лаборатори” дэд хөтөлбөрийг дэмжин, ажиллах	- Дэд хөтөлбөр дэмжин ажиллах журам – 1

3. НИЙГЭМД НӨЛӨӨ БҮХИЙ ЖИШИГ БАЙГУУЛЛАГА БОЛОХ СТРАТЕГИ

Зорилт 3.1 Их сургуулийн засаглал, удирдлагын оновчтой тогтолцоог бүрдүүлж, нээлттэй, ил тод, үр ашигтай, ухаалаг зохион байгуулалт бүхий жишиг байгууллага болох

Хэрэгжүүлэх стратеги	Шалгуур үзүүлэлт
3.1.1 Засаглалын оновчтой загварыг хэрэгжүүлэх, Удирдах Зөвлөлийн манлайллыг дэмжих, байгууллагын шийдвэр гаргах үйл явцад багш, ажилтан, оюутан, ажил олгогч, төгсөгч зэрэг талуудын оролцоог хангасан удирдлагын оновчтой, үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх	- ХҮИС-ийн дүрэм, Удирдах зөвлөлийн журам, Эрдмийн зөвлөлийн журам, бусад шинээр эсвэл шинэчилж боловсруулж, хэрэгжүүлсэн журмын тоо
3.1.2 Сургалт, судалгааны таатай орчин, урт хугацааны хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүрдүүлэх нөхцлийг хангасан үр ашигтай, ил тод зохицуулалт бий болгож хэрэгжүүлэх	- Жилийн төсөв дэх хөрөнгө оруулалтын хэмжээ нийт төсвийн зарлагын 10 хувь
3.1.3 Байгууллагын чанарын баталгаажууллыг дэмжсэн Стратегийн удирдлага, удирдлагын мэдээллийн	- Удирдлагын мэдээллийн систем нэвтрүүлэх (ERP) ажлыг 50 хувьд хүргэх

	систем бүрдүүлэх	
3.1.4	Байгууллагын үйл ажиллагаанд ISO болон үндэсний чанарын стандартыг нэвтрүүлэх	- ISO9000, ISO14000 серийн стандартууд нэвтрүүлж, гэрчилгээ авах
3.1.5	Улсын төсөв, гэрээт ажил, судалгаа, зөвлөх үйлчилгээ, хандив болон орлого нэмэгдүүлэх бусад үйл ажиллагааг хамарсан санхүүжилтийн олон эх үүсвэрийг бүрдүүлэх	- Сургалтын төлбөрийн бус орлогын нийт орлогод эзлэх хувийн жин – 20 хувь
3.1.6	Багш нарын хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, шилдэг боловсон хүчнийг татах, тогтвортой ажиллуулах хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх (цалин, урамшуулал, зэрэглэл, г.м.)	- Цалингийн сүлжээг оновчтой тогтоох (Удирдах зөвлөлийн шийдвэр) - Гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх - Шинээр багш, ажилтанг сонгож шалгаруулахад тавих шаардлагыг тодорхойлох – 1 багц баримт бичиг
3.1.7	Байгууллагын магадлан итгэмжлэл хийлгэх	- Магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авах
3.1.8	Сургалт, судалгааны эко орчныг бүрдүүлэх (хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээгдэх эрчим хүч ашиглах, ус хэмнэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зэрэг) цогц хөтөлбөр хэрэгжүүлэх	- Цогц хөтөлбөр боловсруулах – 1 бичиг баримт - Эко орчинд чиглэсэн хөрөнгө оруулалтын хэмжээ (стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаанд) 40 сая төгрөг
3.1.9	ХҮИС-ийг хөгжүүлэх сан байгуулах	- Сангийн дүрэм – 1 багц бичиг баримт - Сангийн хөрөнгө (2022 оноос хойш жил бүр) – 200 000 сая төгрөг

Зорилт 3.2 Нийгэм дэх нэр хүндийг нэмэгдүүлэх, эерэг имижийг бүрдүүлэх

	Хэрэгжүүлэх стратеги	Шалгуур үзүүлэлт
3.2.1	ХҮИС-ийн ерөнхий нэр хүнд, олон түмэнд хүрэх имиж, брэндийг эерэгээр төлөвшүүлэх мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн цогц арга хэмжээг төлөвлөн системтэй хэрэгжүүлэх; “Ёс зүйтэй бизнес”, “ногоон бизнес”, “худалдаа, үйлдвэрлэлд түшиглэсэн хөтөлбөр”-ийг брэнд болгон, сургалтын хөтөлбөрүүдийг зорилтод бүлгүүдэд хүргэх, сурталчлан нөлөөлөх талаар маркетингийн идэвхитэй бодлого, кампанит ажил зохион байгуулах	- Маркетингийн төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэх
3.2.2	Нийгэм-эдийн засгийн тулгамдсан асуудлаар хурал, хэлэлцүүлэг, нэвтрүүлэг, арга хэмжээ, эвент зохион байгуулах	- Зохион байгуулах арга хэмжээний тоо (жилд) – 2-оос доошгүй
3.2.3	Их сургуулийн чансааг олон улсын	- Олон улсад их сургуулийн эрэмбэ

аргачлалаар үнэлж, бизнесийн чиглэлийн тэргүүлэх сургуулиудын үзүүлэлтэд хүрэхийг эрмэлзэх	тогтоодог QS-т үзүүлэлтийг хангах бэлтгэл ажил – 35 хувь
3.2.4 Төгсөгчдийн холбоог идэвхжүүлэх, төгсөгчдөд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх	- Төгсөгчдөд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний тоо (2 жилд) – 1 удаа
3.2.5 Сайн үйлсийн төлөөх оюутны сайн дурын хөтөлбөр хэрэгжүүлэх	- Хөтөлбөрт оролцсон оюутны тоо (стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаанд) – 700-аас доошгүй
3.2.6 Нийгэмд үзүүлэх нөлөөний хүрээнд стратегийн түншүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн тэлэх, ЭШБ-тай мэдээлэл солилцох хамтын ажиллагааг хөгжүүлэх	- Стратегийн түнш Аж ахуйн нэгж, байгууллагын тоо – 5 - Хамтран хэрэгжүүлсэн ажил, санаачлагын тоо жилд – 1

4. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	2019 оны түвшин	2021 онд хүрэх түвшин	2025 онд хүрэх түвшин
1	Олон улсын ACBSP байгууллагаар магадлан итгэмжлүүлсэн бизнесийн удирдлагын хөтөлбөрийн тоо Үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийн тоо	0	5	9 5
2	Эрдмийн зэрэгтэй багш нарын нийт үндсэн багшид эзлэх хувийн жин	29	35	40 хувь
3	Үндэсний болон олон улсын хянан магадлагддаг мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо (жилд)	6	20	49 хувь
4	Тэтгэлэгт хамрагдсан шилдэг суралцагчдын нийт суралцагчдад эзлэх хувийн жин	0	2	5 хувь
5	Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин	0	35	65 хувь
6	Суралцагчдын сэтгэл ханамжийн түвшин	60	70	80 хувь
7	Түшиц лаборатори сургалтын лаборатори сургалт, судалгаа, туршилтын төв хаб үйлдвэрлэлийн дадлагын бааз сургуулийн дадлагын бааз	0 0 0 0 8 0	0 1 0 1 24 1	1 2 1 3 60 ААНБ 2
8	Сургалтын төлбөрийн бус орлого (жилийн нийт орлогод эзлэх хувь)	0	5	20 хувь
9	ISO9000, ISO14000 серийн стандартуудыг хэрэгжүүлэх	аваагүй		гэрчилгээ авсан байна

5. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа

Тус стратегийн төлөвлөгөө нь 2019-2025 он хүртэл 7 жилийн хугацаанд хэрэгжинэ. Дараах 2 үе шаттай хэрэгжүүлнэ. Үүнд:

I үе шат:	2019-2021	Бэлтгэл үе
II үе шат:	2022-2025	Хэрэгжилтийн үе

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилт

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Их сургуулийн өөрийн төсөв
- Олон улсын төсөл, хөтөлбөр
- Улсын төсөв
- Хандив, тусламж
- Бусад эх үүсвэр

Хяналт-шинжилгээ, үнэлгээ

- Стратегийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 жилд тутам хийнэ.
- Стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн баг тайлангаа тухайн жилийн нэгдүгээр улиралд багтаан Сургуулийн захиргааны зөвлөлд танилцуулна. Сургуулийн захиргаа Удирдах зөвлөлд нэгтгэн танилцуулна.
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт болон Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн стратегийн төлөвлөгөөнд нэмэлт оруулж болно.

6. ХҮИС-ийн СУРГАЛТЫН БОЛОМЖИТ ХӨТӨЛБӨРҮҮД

ХҮИС нь дараах 6 үндсэн чиглэлээр бакалавр болон магистрын зэрэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой бөгөөд чиглэл бүрийн хүрээнд оюутан өөрийн сонголтоор илүү нарийвчилсан чиглэлээр мэргэших боломжийг олгоно.

Хүснэгт 3. Бизнесийн эдийн засаг (Business Economics or Managerial Economics)

Мэргэшүүлэх боломжтой чиглэл (concentration, specialization, or track)	Мэргэшүүлэх хичээлүүдийн жишээ (concentration/specialization courses)
1. Бизнесийн эдийн засаг (Business Economics or Managerial Economics) – ерөнхий	<ul style="list-style-type: none"> - Макроэкономикс I, II - Микроэкономикс I, II - Менежментийн экономикс - Статистик, эконометрикс
2. Бизнесийн шинжилгээ (Business Intelligence and Analytics)	<ul style="list-style-type: none"> - Бизнесийн статистик (Business Statistics) - Big Data Statistics/Big Data Computing - Программчлал (Analytics Programming) - Мэдээллийн сангийн удирдлага (Database Management Systems) - Digital Marketing Analytics - Бизнесийн мэдээлэл (Business Intelligence) - Удирдлагын мэдээллийн систем (Management Information Systems)
3. Бизнес, эдийн засгийн боловсрол (багшийн хөтөлбөр) (Business and Economics for Secondary Education)	<ul style="list-style-type: none"> - Сурган заах арга зүй (Teaching Methodology) - Сэтгэл судлал (Psychology) - Экономиксийн хичээлүүд (Economics) - Бизнесийн суурь хичээлүүд (Business)

Хүснэгт 4. Санхүү (Finance)

Мэргэшүүлэх боломжтой чиглэл (concentration, specialization, or track)	Мэргэшүүлэх хичээлүүдийн жишээ (specialization courses)
1. Санхүү (ерөнхий)	<ul style="list-style-type: none"> - Хөрөнгө оруулалт ба санхүүгийн шийдвэр гаргалт (Capital Investment and Financing Decisions) - Хөрөнгө оруулалтын шинжилгээ (Investment Analysis) - Санхүүгийн загварчлал (Financial Modeling) - Компанийн санхүү (Corporate Finance)
2. Банк (Banking)	<ul style="list-style-type: none"> - Мөнгө ба хөрөнгийн зах зээл (Money and Capital Markets) - Санхүүгийн байгууллагын менежмент (Financial

	<p>Institutions Management)</p> <ul style="list-style-type: none"> - Банкны тогтолцоо/үйл ажиллагаа (Introduction to Banking) - Санхүүгийн байгууллага ба санхүүгийн зах зээл (Financial Institutions and Markets) - Мөнгө, банк ба санхүү (Money, Banking and Finance)
3. Эрсдэлийн удирдлага/даатгал/актуар (Risk Management, Insurance and Actuarial Studies)	<ul style="list-style-type: none"> - Санхүүгийн эрсдэлийн менежмент (Financial Risk Management) - Санхүүгийн мэдээлэл ба шийдвэр гаргалт (Financial Information for Decision Making) - Даатгалын үндэс (Introduction to Risk Management and Insurance) - Нийгмийн даатгал (Employee Benefits) - Даатгалын үйл ажиллагаа (Insurance Operations) - Хөрөнгө оруулалтын актуарын шинжилгээ (Actuarial Aspects of Investment Practice) - Актуарын загварчлал (Actuarial Modeling Methods) - Статистик ба магадлалын онол (Statistics and Probability Theory)
4. Үл хөдлөх хөрөнгө, хөрөнгийн зах зээл (Real Estate and Securities Market)	<ul style="list-style-type: none"> - Үл хөдлөх хөрөнгийн санхүү (Real Estate Finance) - Санхүүгийн портфолио менежмент (Quantitative Portfolio Management) - Хөрөнгийн зах зээл: Опцион ба фьючерс (Options and Futures) - Хөрөнгө оруулалт ба корпорацийн санхүү (Investment and Corporate Finance)
5. Олон улсын санхүү (International Finance)	<ul style="list-style-type: none"> - Олон улсын санхүү (International Finance) - Олон улсын бизнесийн/худалдааны эрх зүй (International Business/Trade Law and Regulations) - Олон улсын эдийн засаг (International Economics) - Олон улсын худалдаа (International Trade)

Хүснэгт 6. Нягтлан бодох бүртгэл (Accounting)

Мэргэшүүлэх боломжтой чиглэл (concentration, specialization, or track)	Мэргэшүүлэх хичээлүүдийн жишээ (specialization courses)
1. Нягтлан бодох бүртгэл (ерөнхий)	<ul style="list-style-type: none"> - Дунд болон ахисан түвшний НББ (Accounting) - Бүртгэлийн мэдээллийн систем (Accounting Information Systems) - Өртгийн менежмент (Cost Management) - Өртгийн бүртгэл (Cost Accounting)

2. Татвар ба аудит (Taxation and Audit)	<ul style="list-style-type: none"> - Орлогын татвар (Income Taxation) - Татварын эрх зүй (Tax Law) - Өртгийн бүртгэл (Cost Accounting) - Аудитын онол ба хэрэглээ (Auditing Theory and Application) - Санхүүгийн тайлангийн шинжилгээ (Financial Statement Analysis) - Удирдлагын бүртгэл (Managerial Accounting) - Бизнесийн татвар (Business Taxation)
---	---

Хүснэгт 7. Худалдаа ба маркетинг (Trade and Marketing)

Мэргэшүүлэх боломжтой чиглэл (concentration, specialization, or track)	Мэргэшүүлэх хичээлүүдийн жишээ (specialization courses)
1. Маркетинг (ерөнхий)	
2. Маркетинг ба брэндийн менежмент (Marketing and Branding)	<ul style="list-style-type: none"> - Хэрэглэгчийн үйл хөдлөл (Consumer Behavior) - Маркетингийн судалгаа (Introductory Marketing Research) - Зар сурталчилгааны менежмент (Promotion Management/Advertising Management) - Олон улсын маркетинг (International Marketing) - Брэндийн стратегийн менежмент (Strategic Brand Management) - Жижиглэнгийн худалдаа ба дистрибьюторын менежмент (Retail and Distribution Management)
3. Бараа боловсруулалт ба мерчандайзинг (Product Development and Merchandizing)	<ul style="list-style-type: none"> - Бараа судлал (Commodity Science/Characteristics) - Мерчандайзингийн үндэс (Introduction to Merchandising) - Социологи (Sociology) - Сэтгэл судлал (Psychology) - Урлаг, бүтээлч байдал ба дизайн (Arts, Creativity and Design) - Гоо зүй (Aesthetics) - Барааны хөгжүүлэлт (боловсруулалт) (Product Development) - Бүтээгдэхүүний шинжилгээ ба өртөг тооцох (Product Analysis and Costing) - Үйлдвэрлэлийн үйл явц (Making it: Materials and Manufacturing Processes) - Бүтээгдэхүүний дизайн (Product Design Studies)
4. Олон улсын худалдаа ба гааль (International Trade and Customs)	<ul style="list-style-type: none"> - Олон улсын эдийн засаг (International Economics)

	<ul style="list-style-type: none"> - Олон улсын худалдааны эрх зүй (International Trade Law) - Гааль (Customs) - Дэлхийн соёл (World Cultures) - Соёлын харилцаа (Intercultural communication) - БНХАУ, ОХУ, Зүүн Ази, Ойрх Дорнод, Баруун Европ, Хойд Америк зэрэг бүс нутгийн бизнес болон зах зээлийн онцлог (Asian, China, Russia, etc Business Topics) - Гадаад зах зээлд нэвтрэх стратеги (Penetrating International Markets) - Бизнесийн мэдээлэл (Business Intelligence) - Олон улсын нийлүүлэлтийн сүлжээ (International Supply Chain)
5. Жижиглэнгийн худалдаа (Retail Trade)	<ul style="list-style-type: none"> - Жижиглэн худалдааны үндэс (Principles of Retailing) - Жижиглэн худалдааны маркетинг (Retail Promotion) - Олон улсын жижиглэнгийн худалдаа (Multinational Retailing) - Бизнесийн эрх зүй (Business Law) - Business Communications - Маркетингийн үндэс (Principles of Marketing)
6. Бөөний худалдаа (Wholesale Trade)	<ul style="list-style-type: none"> - Бөөний худалдааны менежмент (Wholesale management) - Бөөний худалдааны борлуулалтын бүртгэл (Wholesale accounting) - Агуулахын аж ахуй (Warehouse and storing) - Бараа материалын хөдөлгөөн, тооллого (Goods movement and inventorization) - Бөөний бараа хуваарилалт, тээвэрлэлт (wholesale distribution)
7. Нийлүүлэлтийн сүлжээний менежмент ба ложистик (Supply Chain Management and Logistics)	<ul style="list-style-type: none"> - Худалдан авалтын менежмент (Procurement Management) - Тээврийн менежмент (Transportation Management) - Олон улсын ложистик ба нийлүүлэлтийн сүлжээ (Global Logistics and Supply Chain Management) - Бизнесийн загвар ба оптимизац (Business Modeling and Optimization) - Бизнес ложистикийн үндэс (Concepts of Business Logistics) - Үйл явцын менежмент (Operations Management)

8. Электрон худалдаа (Electronic Commerce)	<ul style="list-style-type: none"> - Электрон худалдааны үндэс (Introduction to Electronic Commerce) - Электрон худалдааны технологийн үндэс (Technology Fundamentals of Electronic Commerce) - Интернет маркетинг (Marketing on the Internet) - Электрон худалдааны эрх зүй ба аюулгүй байдал (Legal, Privacy and Security Issues in Electronic Commerce) - Программчлал (Java Programming for the Internet) - Дижитал маркетинг (Digital Marketing) - Нийгмийн сүлжээний маркетинг (Social Media Marketing)
--	--

Хүснэгт 8. Менежмент (Management)

Мэргэшүүлэх боломжтой чиглэл (concentration, specialization, or track)	Мэргэшүүлэх хичээлүүдийн жишээ (specialization courses)
1. Менежмент (ерөнхий)	<ul style="list-style-type: none"> - Байгууллын үйл хөдлөлийн шинжилгээ (Analysis of Organizational Behavior) - Стратегийн удирдлага (Strategic Management) - Introduction to International Business - Хэлэлцээр ба зөрчлийн шийдэл (Negotiations and Conflict Resolution) - Жижиг бизнесийн менежмент (Small Business Management) - Энтрепренершип ба венчур бизнес (Entrepreneurship and Venture Creation) - Үйлчилгээний маркетингийн менежмент (Services Marketing Management)
2. Аялал жуулчлал ба зочлох үйлчилгээний менежмент (Tourism and Hospitality Management)	<ul style="list-style-type: none"> - Аялал жуулчлалын бизнес (Introduction to the business of tourism) - Аялал жуулчлалын түүх ба газар зүй (History and Geography of Tourism) - Аялал жуулчлалын хөгжил (Development of Tourism) - Зочлох үйлчилгээний салбар (Introduction to the Hospitality Industry) - Аялал жуулчлалын менежмент (Introduction to Tourism Management) - Аялал жуулчлалын мэдээллийн технологи (Tourism Information Technology) - Зочлох үйлчилгээний менежмент (Hospitality Management) - Аялал жуулчлалын товчооны үйл ажиллагаа ба менежмент (Travel agency operations and

	<ul style="list-style-type: none"> management) - Хэрэглэгчийн үйлчилгээ (Customer Service) - Хоол хүнс ба хоолны цэсний төлөвлөлт (Principles of Nutrition and Menu Planning) - Нийтийн хоол ба ундааны үйл ажиллагаа (Food and Beverage Operations) - Аялал жуулчлалын зан үйл ба ёс зүй (Behavior and Etiquette in Tourism) - Үйлчилгээний маркетинг (Services Marketing)
3. Хүний нөөцийн удирдлага (Human Resource Management)	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын олон шинж чанар (Diversity in Organizations) - Хөдөлмөрийн эрх зүй ба хөдөлмөрийн харилцаа (Labor Relations) - Хэлцэл хийх стратеги (Negotiation Strategies) - Байгууллагын хүний нөөцийн удирдлага (Managing People in Organisations) - Хүний нөөцийн хөгжил (People Development in Organisations) - Байгууллагын манлайлал ба удирдлага (Leading and Managing in Organisations)
4. Ногоон бизнес ба тогтвортой хөгжил (Green Business and Sustainable Development)	<ul style="list-style-type: none"> - Хүрээлэн буй орчинтой холбоотой байгалийн ухааны хичээлүүд – Биологи, хими, экологи, хүрээлэн буй орчин судлал г.м. - Экологи ба тогтвортой хөгжлийн менежмент (Ecology for Sustainable Management) - Байгалийн нөөцийн менежмент (Natural Resource Management) - Байгууллагын төлөв байдал ба тогтвортой байдал (Organizational Behavior and Sustainability) - Хүрээлэн буй орчин ба нийгэм (Environment and Society) - (Sustainable Organizational Finance) - Хүрээлэн буй орчны эдийн засаг (Environmental Economics) - Ёс зүй ба тогтвортой бизнес (Ethics and Sustainable Business) - Тогтвортой бизнесийн менежмент (Sustainable Business Management, Industrial Ecology)
5. Энтрепренершип ба байгууллагын инноваци (Entrepreneurship and Corporate Innovation)	<ul style="list-style-type: none"> - Энтрепренерийн ур чадвар ба инноваци (Entrepreneurial Creativity and Innovation) - Жижиг бизнесийн санхүүжилт (Small Business Finance) - Энтрепренерийн бизнес төлөвлөлт (Entrepreneurial Business Planning) - Даяаршил ба энтрепренершип (Global

	<p>Entrepreneurship)</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн энтэрпренершип (Social Entrepreneurship) - Бизнесийн төлөвлөлт (Business Plan) - Бизнесийн загварын дизайн (Business Model Design) - Технологи ба инновацийн менежмент (Technology and Innovation Management)
6. Нийгмийн хариуцлага ба нийгмийн энтэрпренершип (Social Responsibility and Social Entrepreneurship)	<ul style="list-style-type: none"> - Бизнесийн нийгмийн хариуцлага (Corporate Social Responsibility) - Нийгмийн энтэрпренершип (Social Entrepreneurship) - Ашгийн бус байгууллагын менежмент (Non-profit management) - Социологи, нийгмийн бодлого ба хөгжил (Sociology, Social Policy and Development) - Хөгжлийн эдийн засаг (Economic Development) - Нийгмийн энтэрпренершип, нийгмийн инноваци ба нийгмийн өөрчлөлт (Social Entrepreneurship, Social Innovation and Innovating Social Change)
7. Стратегийн удирдлага ба манлайлал (Strategic Management and Leadership)	<ul style="list-style-type: none"> - Стратегийн удирдлага (Strategic Management) - Байгууллагын манлайлал ба удирдлага (Leading and Managing in Organisations) - Манлайлал ба харилцаа (Communication for Effective Leadership) - Бизнесийн манлайлал: Ёс зүй ба нийгмийн хариуцлага (Business Leadership: Ethics and Social Responsibility) - Асуудал шийдвэрлэх ур чадвар (Problem Solving: Critical and Strategic Thinking) - Манлайлал ба нөлөөлөл (Leadership and Influence in Action)
8. Удирдлагын мэдээллийн систем (Management Information Systems)	<ul style="list-style-type: none"> - Программчлал (Programming) - Мэдээллийн сангийн удирдлага (Database Management Systems) - Удирдлагын мэдээллийн систем (Management Information Systems) - Мэдээллийн технологийн бизнесийн хэрэглээ (Applications of Information Technology for Business) - Тооцоолол I, II (Introduction to Computing I, II) - Тооцооллын математик аргачлал (Mathematical Methods I, Discrete Mathematics for Computing)

Хүснэгт 9. Бизнесийн эрх зүй (Business Law) ба Бизнесийн сэтгэл судлал (Business Psychology)

Мэргэшүүлэх боломжтой чиглэл (concentration, specialization, or track)	Мэргэшүүлэх хичээлүүдийн жишээ (specialization courses)
Бизнесийн эрх зүй (Business Law)	<ul style="list-style-type: none"> - Эрх зүйн үндэс (Legal Foundations) - Гэрээний эрх зүй (Contract Law) - Арилжааны эрх зүй (Commerical Law) - Компанийн эрх зүй (Corporate Law) - Санхүүгийн эрх зүй (Finance Law) - Татварын эрх зүй (Tax Law)
Бизнесийн сэтгэл судлал (Business Psychology)	<ul style="list-style-type: none"> - Сэтгэл судлал ба судалгааны арга зүй (General Psychology and Research Methods) - Бизнесийн сэтгэл судлалын үндэс (Introduction to Psychology for Business) - Бизнесийн ёс зүй (Business Ethics) - Байгууллагын үйл хөдлөл 1: Хувь хүний гүйцэтгэлийн менежмент (Organisation Behaviour 1: Managing the Performance of Individuals) - Байгууллагын үйл хөдлөл 2: Баг болон бүлгийн менежмент (Organisational Behaviour 2: Managing Groups and Teams) - Бизнесийн ба менежментийн сэтгэл судлал (Business and Management Psychology) - Нийгмийн сэтгэл судлал (Social Psychology) - Соёл хоорондын менежмент (Cross-Cultural Management) - Туршилтын судалгааны дизайн ба шинжилгээ (Analysis and Design of Experiments)

**СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦААНД ТУСГАЙЛАН БОЛОВСРУУЛЖ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД**

ХҮИС-ийн стратегийн шинэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаанд дараах томоохон төсөл хөтөлбөрүүдийг тусгайлан боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Эдгээр төсөл хөтөлбөрийг боловсруулан үр дүнтэй хэрэгжүүлэх нь стратегийн төлөвлөгөөний гол зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой болно.

Хүснэгт 10: 2019- 2025 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Хугацаа	Тодорхойлолт, үндэслэл
1	ХҮИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр	2019-2025	ХҮИС-ийн хүний нөөцийг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх, багшийн хөгжлийг хангах тусгай хөтөлбөр байна. Энэ нь мэргэжлийн хөтөлбөр бүрээр манлайллыг хангах профессорын баг, зөвлөх, экспертүүд, судлаачдын багуудыг бүрдүүлэх, чадавхжуулахад чиглэгдэнэ.
2	Олон талын зориулалт бүхий сургалтын комплекс байр байгуулах төсөл	2020-2023	Цахим номын сан, бизнес инкубатор, хаб, хамтын бизнесийн оффис, гарааны бизнесийн дэмжих төв, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, оюутны үйлчилгээний цогцолбор бүхий сургалтын комплекс байрны зураг төсвийг боловсруулан, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг оновчтой бүрдүүлж ашиглалтанд оруулна.
3	ХҮИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны чадавх бэхжүүлэх хөтөлбөр	2020-2025	ХҮИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлүүдээр түшиц төвүүдийг байгуулан, зөвлөгөө өгөх чадавхийг бий болгох хөгжүүлэх зорилго бүхий дунд хугацааны хөтөлбөр байна.
4	ХҮИС-ийн нэр хүнд, эрэмбэ, чансааг дээшлүүлэх хөтөлбөр	2020-2025	Худалдаа, бизнесийн тэргүүлэх их сургууль болсныг харуулах гол үзүүлэлт нь нэр хүнд, үндэсний болон олон улсад эзэлж буй эрэмбэ, чансаа болно. Иймд энэ асуудлаар тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай.
5	ХҮИС-ийн сургалт-үйлдвэрлэлийн түншлэл хөгжүүлэх хөтөлбөр	2021-2025	“Хийнгээ суралцах” үзэл баримтлалыг сургалтад нэвтрүүлэхийн тулд урт хугацааны тогтвортой түншлэлийг бий болгон, хөгжүүлэхэд чиглэгдсэн тусгайлсан хөтөлбөр юм.
6	Бэлтгэл үеийн хөтөлбөр	2018-2020	“Хийнгээ суралцах” үзэл баримтлалыг ажил хэрэг болгохын тулд ижил төрлийн хөтөлбөрүүдээс ялгарах онцлог бүхий хөтөлбөрүүд боловсруулах, түншлэлийн түшиц газруудыг тодорхойлж хамтын ажиллагааны гэрээ байгуулах, багш нарын цагийн ачааллыг зохицуулах, кейс сургалтын санг бүрдүүлэх, цахим хичээлийн сан бий болгох, багш нарын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах зэрэг цогц үйл ажиллагааг багтаасан бэлтгэл үеийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХҮИС-ийн 2025 он хүртэлх стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн дийлэнх хэсэг нь ХҮИС-ийн өөрийн төсөв хөрөнгөөс бүрдэнэ. Учир нь стратегийн төлөвлөгөөнд туссан үйл ажиллагаануудыг ХҮИС-ийн профессор, багш, ажиллагсад өөрсдийн үндсэн чиг үүргийн хүрээнд хийж гүйцэтгэх бүрэн боломжтой. Харин зарим томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд сургуулийн төсөв хөрөнгө хүрэлцэхгүй, санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрүүдийг босгох хэрэгцээ шаардлага үүснэ. Санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрээс санхүүжүүлэх шаардлагатай дараах төслүүдийн жагсаалтыг хүснэгтэнд нэгтгэв.

Хүснэгт 11. Нэмэлт санхүүжилтийн хэрэгцээ

№	Төсөл	Хүчин чадал /орчин/цар хүрээ	Шаардагдах төсөв, санхүүжилт (төг)
1	Олон талт зориулалт бүхий сургалтын цогцолбор	Нийт 10,000 м ² талбай бүхий 10 давхар барилга	10 тэрбум
2	Сургалтын цогцолборын тоног төхөөрөмж, тавилга	Цогцолборын нийт өрөө тасалгаа, лабораторийг тоноглох	3 тэрбум
3	Харзтайн амралтыг тохижуулж оюутны дадлагын болон олон улсын зуны сургалтын бааз болгох	Оюутны амьдрах, суралцах, дадлага хийх нөхцөлийг бүрдүүлэх	2 тэрбум
4	ХҮИС-ийн оюутны байранд их засвар, иж бүрэн тохижилт хийх	Оюутны байрыг амьдрах болон суралцах хамт олон "Living & Learning Community" болгох	2 тэрбум
5	Барааны чанарын экспертизийн лаборатори байгуулах	Хүнс, өргөн хэрэглээний бүх төрлийн бараанд экспертиз хийх	1 тэрбум
6	Байгууллагын нөөц төлөвлөлтийн систем "Enterprise Resources Planning (ERP)" систем нэвтрүүлэх	ХҮИС-ийн бүхий л үйл ажиллагааг хамарсан байх	500 сая
7	Хичээлийн I, II байрны тавилга, тоног төхөөрөмжийг шинэчлэх	Хичээлийн анги, танхимын орчин нөхцөлийг сайжруулах	500 сая
Нийт дүн			19 тэрбум

ХАВСРАЛТ

МОНГОЛ-АНГЛИ НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Хийнгээ суралцах	Experiential learning
Тонгоруу сургалтын арга	Flipped classroom model
Кейсд суурилсан арга	Case based learning
Асуудалд суурилсан арга	Problem based learning
Төсөлд суурилсан арга	Project based learning
Симуляци	Simulation
Солилцоо	Mobility
Нэгж хичээлийн хөтөлбөр	Syllabus
Ижилсүүлэх хөтөлбөр	Twinning program
Олон улсын зуны сургалтын хөтөлбөр	International summer school
Аж ахуйн нэгж, байгууллагын нэрэмжит тэтгэлэг	Industry-sponsored scholarship
Бие биедээ заах ба суралцах	Peer Learning and Teaching
Менторшип	Mentoring



ХҮИС

SINCE 1924

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль
8-р хороо, Оюутны гудамж, 14/3
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот

Утас: 976-7511-8989
Email: info@nucb.edu.mn
Web: www.nucb.edu.mn